

Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг
тооцох зөвлөмж

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 3² дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг хэрэглээний үнийн өөрчлөлт, цалин хөлсний өсөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасны дагуу тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцоолоход энэхүү зөвлөмжийг ашиглана.

Хоёр. Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг
тооцоолоход ашиглах мэдээлэл

2.1. Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцоолоход дараах мэдээллийг ашиглана. Үүнд:

2.1.1. Хэрэглээний үнийн индекс (**X**)-ийг тооцоолохдоо 1990 оныг 1991 оны хэрэглээний үнийн индексийг 2 дахин бууруулж, 1991 оноос хойшхи хугацааны хувьд Үндэсний статистикийн хорооны зарласан хэрэглээний үнийн улсын индексээр тооцоолно.

$$X = \begin{pmatrix} X_{1990} \\ \dots \\ X_n \end{pmatrix}$$

Тайлбайр:

X- Хэрэглээний үнийн индекс

n- Он

2.1.2. 1995 оноос өмнөх Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин(**Y**)-г Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газар хамтран тооцоолж гаргана. 1995 оноос хойших аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг Үндэсний статистикийн хорооны зарласан аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингаар тооцоолно.

$$Y = \begin{pmatrix} Y_{1990} \\ \dots \\ Y_n \end{pmatrix}$$

Тайлбар:

Y- Ажилчдын дундаж цалин

n- Он

Гурав. Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцоолох аргачлал

3.1. Зөвлөмжийн 2.1-д дурдсан мэдээллийг ашиглан тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцоолно . Үүнд:

3.1.1. Хэрэглээний үнийн индексээс бодсон итгэлцүүрийг дараах байдлаар гаргана.

$$K_n = \begin{pmatrix} \frac{x_n}{x_{1990}} \\ \dots \\ \frac{x_n}{x_n} \end{pmatrix}$$

Тайлбар:

K-Хэрэглээний үнийн индексээс бодсон итгэлцүүр

n-Суурь он буюу итгэлцүүрээр өсгөх хамгийн сүүлийн он

3.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингаас бодсон итгэлцүүрийг дараах байдлаар гаргана.

$$S_n = \begin{pmatrix} \frac{Y_n}{Y_{1990}} \\ \dots \\ \frac{Y_n}{Y_n} \end{pmatrix}$$

Тайлбар:

S-Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингаас бодсон итгэлцүүр

n-Суурь он буюу итгэлцүүрээр өсгөх хамгийн сүүлийн он

3.1.3. Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг дараах аргачлалаар тооцоолно.

$$\begin{cases} H = A * S + B * K \\ A + B = 1 \end{cases}$$

Тайлбар:

H -хосолмол индексийн аргачлалаар бодсон шинэ итгэлцүүр
A- Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингаас бодсон итгэлцүүрийг тохируулах коэффициент
B-Хэрэглээний үнийн индексээс бодсон итгэлцүүрийг тохируулах коэффициент

Дөрөв. Тооцоолол хянах

4.1. Энэхүү зөвлөмжийг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцоолсон үр дүнг Үндэсний статистикийн хороо хянана.

---oOo---

ТӨСӨЛ